



# СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

№73 /517/

2023.05.04

Цаг үе, үйл явдал

## ТҮЛШ ЗАРЦУУЛАЛТ БАГАТАЙ АЧААНЫ АВТОМАШИНУУДЫГ ЗАРИМ АНГИ, САЛБАРУУДАД ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Зэвсэгт хүчний 089 дүгээр ангид ажиллалаа. Түүнийг дагалдаж Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр нар ажилласан юм.

Батлан хамгаалахын сайдыг Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 089 дүгээр ангид хүрэлцэн ирэхэд Улаанбаатар цэргийн хүрээний Хүндэт харуул, тус ангийн нийт бие бүрэлдэхүүн хүндэтгэн угтаж авсны дараа ангийн захирагч дэд хурандаа Д.Мөнхбаатар ангийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлуудаа уламжиллаа.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр

тус ангид ажиллах үеэрээ Зэвсэгт хүчний зарим нэгтгэл, анги, салбарт бага оврын ачааны автомашинуудыг зарим анги, салбаруудад тогтмол ажиллаж барилга байгууламж, зэвсэглэл, техник хэрэгслийн бэлэн байдалтай танилцаж, ажилтан албан хаагчдынхаа санал хүсэлтийг сонсож аливаа төрийн бодлогод тусгаж, дэмжлэг үзүүлэхийг хичээсээр ирсэн.

Тэрээр автомашин гардан авсан ангийн захирагч нарт хандаж хэлсэн үгэндээ "Миний бие Батлан хамгаалахын сайдын албан тушаалд томилогдсоноос өдийг хүртэлх хугацаанд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад тогтмол ажиллаж барилга байгууламж, зэвсэглэл, техник хэрэгслийн бэлэн байдалтай танилцаж, ажилтан албан хаагчдынхаа санал хүсэлтийг сонсож аливаа төрийн бодлогод тусгаж, дэмжлэг үзүүлэхийг хичээсээр ирсэн.

Энэ удаад ангийн өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулахдаа хүнд оврын, түлш зарцуулалт өндөртэй техник хэрэгсэл ашиглаж буй

анги, салбаруудад эдийн засгийн хувьд хэмнэлттэй бага оврын ачааны автомашинуудыг хүлээлгэн өгч байна. Монгол Улсын Засгийн газраас Хэмнэлтийн тухай хуулийг баталж хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосны дагуу Батлан хамгаалах яамнаас Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын дарга нарыг албаны зориулалтын автомашинуудыг хувьдаа хэрэглэх, эзэмших эрхийг цуцалж техник хэрэгсэл нэн хэрэгцээтэй газруудад дахин хуваарилсныг та бүхэн мэдэж байгаа. Хэдий улс орны эдийн засгийн байдал хүндхэн байгаа ч Батлан хамгаалах яамнаас анги, байгууллагуудын зэвсэглэл, техник хэрэгслүүдийг сайжруулж, ажилтан алба хаагчдынхаа нийгмийн хамгааллын асуудалд анхаарч шийдвэрлэхийн төлөө хүчин чармайлт гарган ажилласаар байх болно" хэмээсэн юм.



## ТОРГОН ЦЭРГҮҮД АВАРГАЛЛАА

Олс таталтын 2023 оны насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын баг тэргүүлж шилдгээр шалгарлаа.

2004 оноос хойш уламжлал болгон зохион байгуулж буй энэхүү тэмцээн нь Монгол Улсад олс таталтын спортыг хөгжүүлэх,

тамирчдын ур чадвар болоод багаар ажиллах түвшинг нэмэгдүүлэх зорилготой билээ.

Тэмцээнд 10 байгууллагын 150 орчим ажилтан, цэргийн алба хаагч оролцож эрэгтэй 620 кг, эмэгтэй 520 кг жин, холимог 580 кг гэсэн төрлөөр өрсөлдөж хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
8	-2


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	29

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,470	3,473
EUR	3,814	3,829
CNY	501.50	502.90
RUB	42	43.80
JPY	26	27.10
KRW	2.70	2.72

### ЗУРХАЙ



2023.05.04 /ПҮРЭВ ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 14

**ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ  
САР  
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР  
НОХОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Эд мал арвидна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.30-20.08

Барилдлага:

Сэрэхүй

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 687,900,631

Эдгэрсэн

Нийт: 658,316,788

Нас барсан

Нийт: 6,859,929

Цахим шууданд

"НОМТОЙ НӨХӨРЛӨӨ"



Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн Суртал хүмүүжил, сэтгэл зүйн албанаас ангийн нийт бие бүрэлдэхүүний дунд "Номтой нөхөрлөө" уриаг гаргаж номын өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгөөр УБХИС-ийн БХУА-ийн багш доктор профессор хурандаа Г.Бүлтэн хүрэлцэн ирж академиас эрхлэн гаргасан ном сургалтын материалуудыг танилцуулсны зэрэгцээ тус академид хэрхэн элсэж орох

талаар үнэтэй мэдээллийг хуваалцлаа.

Үргэлжлүүлэн тэрбээр "Цэргийн ухааны урлаг, офицер ахлагчийн тактикийн сэтгэлгээг хөгжүүлэх нь" сэдвээр яриа хийж ажилтан, алба хаагчдын сонирхсон асуултад хариулсан юм.

Тус өдөрлөг нь ном уншихын ач тусыг сурталчлан таниулсан, үнэтэй мэдээ мэдээллээр баялаг, өндөр ач холбогдол бүхий байсан талаар оролцогчид онцолж ахин энэ төрлийн үйл ажиллагааг зохион байгуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байлаа.



"ЦАЦРАГИЙН ОСЛЫН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ" СЭДЭВТ ХАМТАРСАН СУРГАЛТААР ...



Зэвсэгт хүчний 119 дүгээр анги, ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын Химийн ажиллагааны салбар, Цөмийн энергийн комиссын Ажлын албаныхантай хамтран "Цацрагийн ослын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ" сэдэвт онол-арга зүйн сургалтыг 05 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төв, цацрагийн үүсгүүрийг түшиглэн зохион байгуулж явууллаа.

Онол-арга зүйн сургалтын зорилго нь цацрагийн ослоос

сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, ослын үед ажиллах мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, чиг үүргийг тодотгох бөгөөд сургалтаар цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх үед гарсан ослын нөхцөлд мэдээллийг шуурхай дамжуулах, хариу арга хэмжээг, эзэнгүй цацрагийн үүсгүүрийг эрэн хайх, аюулгүй болгох дадлага, сургуулийг амжилттай хийж гүйцэтгэлээ.

Цацрагийн ослын бэлэн байдлыг хангуулах, ослын нөхцөлд ажиллах, хариу арга хэмжээ авах дадлага, сургууль нь холбогдох мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааг сайжруулах, хариу арга хэмжээг оновчтой төлөвлөх, ослын хор уршгийг хязгаарлах, үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдыг авах тунг багасгахад чухал ач холбогдолтой сургалт болсон юм.

Сургалтыг удирдан зохион байгуулсан ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын Хими, биологи, цацрагийн асуудал хариуцсан мэргэжилтэн хошууч У.Ганзориг, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Ажиллагааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа Ж.Эрдэнэцогт нар үр дүнтэй арга хэмжээ болсныг оролцогчдод онцолж, талархал илэрхийлсэн юм.

ҮНДЭСНИЙ ХЭЛ, БИЧГЭЭ ХИЛИЙН ЧАНАДАД СУРТАЛЧИЛЖ БАЙНА



Жил бүрийн тавдугаар сарын эхний ням гарагт эх хэл, үндэсний бичгийн баяраа албан ёсоор тэмдэглэж эхэлснээс хойш 20 дахь жилтэйгээ золгож байна.

"Бид эх хэл, үндэсний бичгээ сурч хамгаална. Судалж хамгаална. Хэрэглэж хамгаална. Эх хэлээр үндэсний агуулга бүтээж, түгээж хамгаална" гэдэгчлэн түүхт энэ өдөр үндэсний хэл, бичгээрээ уран яруу бичиж, бусдадаа сурталчлан таниулж яваа олон офицер, ахлагч, түрүүч, байлдагч, сонсогчдын төлөөлөл болгож Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн Соёл хүмүүжлийн офицер, ахлах дэслэгч Б.Долгорсүрэн онцолж байна.

Тэрээр 2017 оноос эхлэн эх бичиг

судлаач, уран бичээч Б.Алтантуяа багшийн "Уран бичлэг"-ийн сургалтад суралцсан цагаас хойш одоог хүртэл бийрэн бичлэгээр суралцаж офицер юм. БХЯ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Монгол бичгийн тэмцээнд 2019, 2022 онуудад "Уран бичлэг"-ийн төрөлд тэргүүн байр эзлэж байсан бөгөөд өдгөө БНӨСУ-д явагдаж буй Нэгдсэн Үндэсний байгууллагын мандаттай UNMISS энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэж байгаа эмэгтэй цэргийн алба хаагчдын нэг.

Ахлах дэслэгч Б.Долгорсүрэн ажиллагааны газар оронд дэлхийн орнуудын энхийг сахиулагчдад үндэсний соёл, бичгээ сурталчлах үүднээс нэрсийг нь уран бичин бэлэглэж, эх орныхоо өв соёлыг түгээн дэлгэрүүлж яваа юм. Түүхт өдөр баярын сэтгэгдлээ хуваалцахдаа "Монгол хүнийг Монгол гэж хэлүүлэх ганц зүйл бол Монгол хэл бичиг. Дэлхийн хэмжээнд гайхалтай гэж үнэлэгдсэн 7 бичиг үсэг байдгийн нэг нь монгол бичиг. Монгол бичиг бол угтаа хүн бичиг гэдэг. Толгой, титэм, гэдэс, шилбэ гээд


хүний бүх шинж чанар түүнд агуулагдаж байдаг учраас тэр. Хуульд зааснаар 2-хон жилийн дараа буюу 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн болон нутгийн өөрөө удирдах бүх байгууллага албан хэргийг кирилл ба монгол бичгээр хөтлөн явуулах болохоор бүх нийтээр хос бичигтэн болоход анхаараасай гэж хүсдэг. Миний хувьд цэргийн багийнхаа удирдлагуудын өгсөн үүргийн дагуу дэлхийн орнуудын Зэвсэгт хүчний удирдлага, албан тушаалтнуудад монгол бичгээрээ нэрийг нь болоод "Баярлалаа" гэдэг үгийг сийлж бэлэглэдэг. Ямар яруу тансаг бичиглэл вэ гэхэд нь их баярладаг шүү" гэсэн юм.

Ташрамд дурдахад, одоогоос яг хагас зуун жилийн өмнө буюу 1973 онд тухайн үеийн БНМАУ бүх нийтээр бичиг үсэгтэн улс болсныг НҮБ зарлаж байжээ.

Монгол туургатнууд дөрвөлжин, тод, соёмбо, төвөд, вагиндра, кирилл гэх мэт олон төрлийн бичиг үсгийг хэрэглэж ирсний дотроос хамгийн удаан бөгөөд тасралтгүй хэрэглэгдсээр ирсэн нь чухамдаа монгол бичиг ажээ.

Ахмад Д.БОЛОР

"А" АНГИЛЛЫН ДАМЖААНЫ СУРГАЛТ ЯВАГДАЖ ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Техникийн бага мэргэжилтэн бэлтгэх төв, Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвтэй хамтран ЗХЖШ-ын даргын тушаалын дагуу Зэвсэгт хүчний хугацаат цэргийн алба хаагчдад мотоцикл жолоодох эрхийн "А" ангиллын дамжааны

сургалтыг явуулж байна.

Сургалтад Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн 40 хугацаат цэргийн алба хаагч хамрагдлаа.

Цаашид хугацаат цэргийн алба хаагчдыг алба хаах хугацаандаа мотоцикл жолоодох эрхийн үнэмлэхтэй болгох "А" ангиллын дамжааны сургалтыг Зэвсэгт хүчний хугацаат цэргийн алба хаагчидтай нэгтгэл, ангиудад ЗХЖШ-ын даргын тушаалын дагуу тогтмол явуулахаар төлөвлөж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБА

СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Зэвсэгт хүчний 189 дүгээр анги Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний

хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах, дэмжлэг үзүүлэх хүрээнд Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран ангийн нийт бие бүрэлдэхүүнд "Газар хөдлөлтийн гамшиг"-ийн талаарх сургалтыг зохион байгуулав.

Сургалтаар тус дүүргийн Онцгой байдлын хэлтсийн сургагч багш Э.Нандинцэцэг, Д.Ууганцэцэг нар хүрэлцэн ирж ажилтан цэргийн алба хаагчдад газар хөдлөлтийн гашгийн үед өөрийгөө болон бусдыг хэрхэн авран хамгаалах талаар үнэтэй зөвлөмж, мэдээ мэдээллийг өгч ажилласан юм.

Хошууч Ц.ЦЭВЭГДОРЖ

ЭРҮҮЛ МЭНД ЭРХЭМ БАЯН



Ажилтан, алба хаагчдад зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маягийг сурталчлан таниулах, мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд Зэвсэгт хүчний 303 дугаар анги, АЗИ ФАРМ ХХК-тай хамтран ангийн байрлалд эрүүл мэндийн өдөрлөгийг зохион байгуулав.

Өдөрлөгөөр тус газрын төлөөлөгч Б.Пүрэвжаргалаар ахлуулсан дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй эмч нарын баг хүрэлцэн ирж нийт бие бүрэлдэхүүнд

эрдсийн шинжилгээг үнэ төлбөргүй хийж тохирсон заавар, зөвлөмжийг өгсний зэрэгцээ амин дэм болон хүнсний нэмэлт тэжээлийн талаар яриа, таниулга хийлээ.

Ангийн нийт бие бүрэлдэхүүнд эрдсийн шинжилгээг хийснээр хүн нэг бүрийн биед агуулагдаж буй эрдсийн хэмжээг тодорхойлж тэдний эрүүл мэндийг сахин хамгаалах олон талт арга хэмжээг авах цаашлаад учирч болзошгүй өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн юм.

